



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/66

Хажуу шинэ ус

Сумын өмч хамгаалах байнгын
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 сарын 15-ны өдөр 09 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлан устгах, данснаас хасах зэргээр эд хөрөнгө зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллах үүрэг бүхий сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Н.Ганбат (Санхүү албаны дарга)

Нарийн бичиг Д.Жаргалмаа (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)

Гишүүд Д. Сарангэрэл (Засаг даргын орлогч)

Г. Булган (Нийгмийн даатгалын байцаагч)

Д.Алтансаргай (Татварын улсын байцаагч)

2.Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон Сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон сум орон нутагт хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн дарга (Н.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН